



**МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ**  
**ГАЗАР ЗҮЙН НЭРИЙН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН СТАНДАРТ**

**MNS \*\*\*\* : 2019**

**Албан хэвлэл**

**СТАНДАРТЧИЛАЛ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР**

Улаанбаатар  
2019 он

## **АГУУЛГА**

ӨМНӨХ ҮГ .....	3
ТАНИЛЦУУЛГА .....	4
ХАМРАХ БА ХЭРЭГЛЭХ ХҮРЭЭ.....	5
НОРМАТИВ ИШЛЭЛ .....	5
НЭГ. ГАЗАР ЗҮЙН НЭРИЙН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ЗАГВАР .....	6
1.1. Ерөнхий мэдээлэл .....	6
1.2. Мэдээллийн сангийн ангилал ба дэд ангилал.....	6
1.3. Мэдээллийн сангийн давхарга.....	9
1.4. Газар зүйн нэр бүрийн дугаарлалт .....	12
1.5. Мэдээллийн сангийн хүснэгтэн мэдээлэл /атрибут/.....	13
ХОЁР. ГАЗАР ЗҮЙН НЭРИЙН МЭДЭЭЛЛИЙН САНД ГАЗАР ЗҮЙН НЭРИЙГ БИЧИХ	16
2.1.Газар зүйн нэрийг бичих аргачлал .....	16
ГУРАВ. ГАЗАР ЗҮЙН НЭРИЙН МЭДЭЭЛЛИЙН САНД ГАЗАР ЗҮЙН НЭРИЙГ	
ЛАТИН ҮСГЭЭР ГАЛИГЛАХ.....	17
ДӨРӨВ. ГАЗАР ЗҮЙН НЭРИЙГ БАЙР ЗҮЙН ЗУРАГТ БИЧИХ.....	18
ТАВ. ДЭВСГЭР БУЮУ АНХДАГЧ АНГИЛЛЫН ТАЙЛБАР .....	18

## ӨМНӨХ ҮГ

Стандартчилал, хэмжил зүйн газар (цаашид СХЗГ гэх) нь олон улсын стандартчиллын байгууллага (ISO)-ын гишүүн бөгөөд үндэсний стандартын төсөл боловсруулах ажлыг Монгол Улсын стандартчиллын тогтолцооны суурь стандарт MNS 1-1:2006, MNS 1-2:2006 стандартын дагуу төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж байгууллагуудтай хамтран хэрэгжүүлдэг.

Тус Газар нь үндэсний стандарт боловсруулах ажлыг холбогдох салбарын техникийн хороогоор дамжуулан гүйцэтгэдэг. Техникийн хороодоор хэлэлцэн, дэмжигдсэн стандартын төсөл нь Стандартчиллын үндэсний зөвлөлийн тогтоолоор баталснаар улсын хэмжээнд хүчин төгөлдөр болно.

Энэхүү стандартыг **2019 оны ТХ-.... /Газрын харилцааны техникийн стандартчилалын хөтөлбөрийн дагуу** Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, Геодези, зураг зүйн хэлтсээс /мэргэжилтэн Б.Мөнх-Лд/ боловсруулав.

Энэ стандартын төслийг **ТХ-49 /Газрын харилцааны техникийн стандартчилалын** хорооны хурлаар хэлэлцэн зөвшилцсөн болно.

Уг стандарт нь Монгол Улсын стандартчиллын тогтолцооны суурь стандарт MNS 1-1:2006, MNS 1-2:2006–ын дагуу хянагдсан.

Стандартчилал, хэмжил зүйн газар  
(СХЗГ): Энхтайваны өргөн чөлөө 46А  
Улаанбаатар-13343 Ш/Х – 48  
Утас: 263860, 266754 Факс (976- 1) 458032  
вэбсайт: [www.masm.gov.mn](http://www.masm.gov.mn)  
[www.estandard.mn](http://www.estandard.mn)

© **СХЗГ 2016** “Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай” Монгол Улсын хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн, эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХЗГ (Стандартчиллын төв байгууллагад)-д байна.

## ТАНИЛЦУУЛГА

Энэхүү стандартыг Газар зүйн нэрийн мэдээллийн сан үүсгэх, хөтлөх, газар зүйн нэрийг 1:25 000, 1:50 000, 1:100 000-ны масштабтай байр зүйн зурагт ашиглахад улсын хэмжээнд дагаж мөрдөнө.

Газар зүйн нэрийн мэдээллийн загвар сан, АНУ-ын Газар зүйн нэрийн стандарт, БНСУ-ын мэдээллийн сан түүний загвар зэргийг ашиглан Монгол улсад Газар зүйн нэрийн мэдээллийн сан үүсгэх, хөтлөх стандарт болгож боловсрууллаа.

Уг стандартад байр зүйн зурагт болон нэрийн мэдээллийн санд дүрслэгдэх Газар зүйн нэрийг 3 үндсэн ангилалд, 12 дэд ангилал, 183 анхдагч ангилалд хуваан цаашид мэдээллийн санг баяжуулах бололцоог бүрдүүлж хийсэн. Ангилал тус бүрийн газар зүйн нэр нь өөртөө мэдээллийн санд дүрслэгдэх хэлбэрийг агуулсан бөгөөд хэлбэр бүр өөр өөрийн гэсэн хүснэгтэн мэдээлэлтэй хийгдсэн нь цаашид орон зайн мэдээллийн суурь болгон байр зүйн зургийг ашиглах бололцоог бүрдүүлэн өгч байгаа юм.

Газар зүйн нэрийн мэдээллийн сан нь Монгол орны газар нутгийн бүх нэрийг багтаасан бие даасан мэдээллийн сан байх ба байр зүйн тоон зурагт шаардлагатай нэрийг энэ мэдээллийн сангаас ерөнхийлчлөх байдлаар гаргаж авч ашиглана.

Мэдээллийн санг Засгийн газрын 2009 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан WGS84 солбицлын тогтолцоонд байгуулж 3 багц өгөгдөл /feature dataset/, 6 давхарга /feature class/, 9 хүснэгтэн мэдээлэлтэй үүсгэнэ. Үндсэн ангиллыг илэрхийлж буй үсэг нь тухайн газар зүйн нэрд өгөх дахин давтагдашгүй дугаарын эхлэл болно.

Уг стандартад газар зүйн нэрийн дэвсгэр нэрийг хэрхэн бичих, оноосон нэрийг хэрхэн бичих, Латин хэлэн хэрхэн галиглахыг зохицуулж өгсөн.

## МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Газар зүйн нэрийн мэдээллийн сан	MNS **** : 2019
----------------------------------	-----------------

Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2019 оны ..... дугаар сарын ...-ны өдрийн .... дүгээр тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь 2019 оны .... дүгээр сарын .....-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

### ХАМРАХ БА ХЭРЭГЛЭХ ХҮРЭЭ

Энэ стандартыг геодези, зураг зүйн үйл ажиллагаа, үйлчилгээ эрхэлдэг бүх байгууллага, аж ахуйн нэгж нь Монгол Улсын нийт газар нутгийн хэмжээнд болон хэсэгчилсэн байдлаар газар зүйн нэрийн мэдээллийн үүсгэх, шинэчлэх, хөтлөхөд мөрдөнө.

### НОРМАТИВ ИШЛЭЛ

Энэхүү стандартад дараах баримт бичгийг ишлэл болгож ашигласан бөгөөд энэ стандарт нь Монгол улсад дагаж мөрдөгдөх газар зүйн нэрийн мэдээллийн сангийн албан ёсны анхны стандарт болно.

Ишлэл болгон ашигласан баримт бичгүүдэд өөрчлөлт орох нь энэ стандартыг шинэчлэх шаардлага болж чадна.

- Монгол газар нутгийн нэрийн зүйлчилсэн толь
- “Байр зүйн зургийн загвар сан, таних тэмдэг, Масштаб:1:25 000, 1:50 000, 1:100 000 MNS 6703 : 2017”,
- “Байр зүйн болон дэвсгэр зургийн загвар сан, таних тэмдэг, Масштаб:1:500, 1:1 000, 1:2 000, 1:5 000, MNS 6702 : 2017” стандарт
- Монгол хэлний их тайлбар толь /цахим/

## НЭГ. ГАЗАР ЗҮЙН НЭРИЙН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ЗАГВАР

### 1.1. Ерөнхий мэдээлэл

Газар зүйн нэрийн мэдээллийн сан нь Монгол орны газар нутгийн бүх нэрийг багтаасан бие даасан мэдээллийн сан байна. Байр зүйн тоон зурагт шаардлагатай нэрийг энэ мэдээллийн сангаас ерөнхийлчлөх байдлаар гаргаж авч ашиглана.

Мэдээллийн санг Засгийн газрын 2009 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан WGS84 солбицлын тогтолцоонд байгуулж 3 багц өгөгдөл /feature dataset/, 6 давхарга /feature class/, 9 хүснэгтэн мэдээлэлтэй үүсгэнэ.

### 1.2. Мэдээллийн сангийн ангилал ба дэд ангилал

Газар зүйн нэрийн мэдээллийн сан нь үндсэн 3 ангилал, 12 дэд ангилалтай байна. Үндсэн 3 ангилалыг мэдээллийн сангийн багц өгөгдөл байдлаар үүсгэнэ. Үүнд:

Н – засаг захиргаа

В – байгаль

F – хүний бүтээсэн

Үндсэн ангилалыг илэрхийлж буй үсэг нь тухайн газар зүйн нэрд өгөх дахин давтагдашгүй дугаарын эхлэл болно. Үндсэн ангилалд байх 12 дэд ангилалыг дараах байдлаар тодорхойлно.

Н. Засаг захиргаа

01. Засаг захиргааны нэгж

02. Суурьшил

В. Байгаль

01. Уул

02. Амьтан, ургамал

03. Хөрс, чулуулаг

04. Ус, зүй

05. Зүг чиг, байршил

06. Уур амьсгал

07. Тогтоц

F. Хүний бүтээсэн

01. Түүхэн дурсгалт

02. Барилга, байгууламж

03. Шашин

Дэд ангилал бүр газар зүйн тогтоцоор анхдагч ангилалд хуваагдана.

Хүснэгт 1 Мэдээллийн сангийн дэд ангилал ба анхдагч ангилал

д/д	Анхдагч ангилал	Дүрслэгдэх хэлбэр	д/д	Анхдагч ангилал	Дүрслэгдэх хэлбэр
<b>01. Засаг захиргааны нэгж</b>					
01	нийслэл	талбай	04	сум	талбай
02	аймаг	талбай	05	хороо	талбай
03	дүүрэг	талбай	06	баг	талбай
<b>02. Суурьшил</b>					
01	хот, суурин	цэг	06	өртөө	цэг
02	гудамж	шугам	07	бригад	цэг
03	талбай	талбай	08	тасаг	цэг
04	хороолол	талбай	09	ферм	цэг
05	хотхон	талбай	10	цех	цэг
<b>01. Түүхэн дурсгалт</b>					

01	туурь	цэг	04	хиргисүүр, хирвэс	цэг
02	хөшөө	цэг	05	цайз хэрэм	цэг
03	балгас	цэг			
<b>02. Барилга, байгууламж</b>					
01	бууц	цэг	08	гүүр	цэг
02	далан	шугам	09	уурхай	цэг
03	өвөлжөө	цэг	10	суурь	цэг
04	шуудуу	шугам	11	хашаа	шугам
05	зам	шугам	12	хороо	цэг
06	өтөг	цэг	13	шан	шугам
07	байшин	цэг			
<b>03. Шашин</b>					
01	суварга	цэг	03	жас	цэг
02	сүм, дуган, хийд	цэг			
<b>01. Уул</b>					
01	аараг	талбай	22	суга	шугам
02	адарга	талбай	23	сэрвэн	талбай
03	ам	шугам	24	таг	шугам
04	асга	шугам	25	тайга	талбай
05	байц	шугам	26	толгод	шугам
06	богоч	цэг	27	толгой, болдог	цэг
07	бөөрөг	талбай	28	уул, хайрхан	цэг
08	бэл	талбай	29	ухаа	шугам
09	даваа, дав, онь	цэг	30	хавцал	шугам
10	дөрөлж	цэг	31	хамар, өвдөг, гээг	шугам
11	ёроол	шугам	32	хормой	шугам
12	зоо	шугам	33	хунх, хүнх	цэг
13	зураа	шугам	34	хүнхэр	цэг
14	зээг	шугам	35	хүр, хүрд	цэг
15	нуруу	шугам	36	хэц	шугам
16	овоо	цэг	37	хяр, хянга	шугам
17	орой, оргил, өндөрлөг, өндөр	цэг	38	хясаа	шугам
18	өвөр	талбай	39	цав	шугам
19	салаа	цэг	40	царам	шугам
20	сархиа, сархиаг, сархид	талбай	41	шил	шугам
21	сарьдаг	шугам	42	энгэр, ташуу, цалуу, нураг, нурган, нахиу	шугам
<b>02. Амьтан, ургамал</b>					
01	айраг	цэг	10	түнгэ, ширэнгэ, шугай	талбай
02	бургас, бут, бударгана,бураа, арц, сондуул, торлог, хармаг, сухай	талбай	11	тэсэг	цэг
03	дэрс	цэг, талбай	12	улиас	цэг, талбай
04	заг	цэг, талбай	13	хаг	цэг
05	мод	цэг	14	хайлаас, хайлс	цэг, талбай
06	нарс	цэг, талбай	15	харгайт	цэг, талбай
07	нуга,ширэг, зүлэг, таана	талбай	16	харгана	цэг, талбай

08	ой, төгөл, хөвч	талбай	17	хулс	цэг, талбай
09	сөөг, шаваг, шарилж	талбай	18	хус, боролж	цэг, талбай
<b>03. Хөрс, чулуулаг</b>					
01	марз, мараа	талбай	06	чулуу	цэг
02	намаг	талбай	07	шал, шавар, шалбааг, лах	талбай
03	сондог	цэг	08	элс, манхан	талбай
04	хайрга, дайрга	талбай	09	явар, цахир, цайдам, борзон	талбай
05	хаш, хүлэр, зэс, гяваат	талбай			
<b>04. Ус зүй</b>					
01	арал	талбай	13	суваг, судаг, татаал	шугам
02	боом	шугам	14	тавилан	шугам
03	булаг	цэг	15	татуурга	шугам
04	гарам, олом	шугам	16	тойром, цөөрөм	талбай
05	гатлага	цэг	17	тохой	цэг
06	гол, харз	шугам	18	ус	цэг
07	горхи	шугам	19	усан сан	цэг, талбай
08	мөрөн	шугам	20	хөвөө	шугам
09	нуур	талбай	21	худаг	цэг
10	рашаан	цэг	22	цутгалан, хүрхэрээ, таргил	цэг
11	сайр, садарга	шугам	23	цүнхэг, цүлхэн, хөв	цэг
12	салаа	цэг	24	шанд	цэг
<b>05. Зүг чиг, байршил</b>					
01	адаг	шугам	09	дэл	шугам
02	ар	талбай	10	зааг	шугам
03	булан	шугам	11	завсар	шугам
04	бэлчир	цэг	12	зах	шугам
05	ганга	шугам	13	урт	шугам
06	говь	талбай	14	уулзвар	цэг
07	гүвээ, гүдгэр, гүдэн, гүрдгэр	шугам	15	үзүүр	цэг
08	дов, довон, довцог	талбай	16	хаяа	цэг
<b>06. Уур амьсгал</b>					
01	зуслан	цэг	03	уур	цэг
02	зэрэглээ	цэг	04	хур	цэг
<b>07. Тогтоц</b>					
01	агуй, хонгил	цэг	18	хонд	цэг
02	ан, ангал, гануу	шугам	19	хонхор, хонх, хунхуй	цэг
03	барзан	шугам	20	хоолой	шугам
04	бүрд	талбай	21	хорголж	цэг
05	гацаа, сүв, мухар	цэг	22	хотгор, хотос	цэг
06	гозгор, шовх, шовгор	цэг	23	хошуу	шугам
07	дэнж, дэвсэг, дэв, хавтгай, ширээ	талбай	24	хөдөө	цэг
08	жалга, гуу, зуух	шугам	25	хөндий	шугам
09	мөргөцөг, мөргүү, мөрөг, ирмэг, хөмөг	шугам	26	хөтөл	цэг



10	овгор, товгор, товог, дүмбэн, оорцог	цэг	27	хургад	цэг
11	огтрого	цэг	28	нүүр, хуруу, шанаа, дух, магнай, сээр, хажуу, сүвээ, хавирга, хөл, сүүл, гуя, тархи	цэг
12	тал	талбай	29	хуудас	цэг
13	тэнгэр	цэг	30	хүрэм	цэг
14	тээг	цэг	31	хүрээ	шугам
15	хад, цохио, цонж	цэг	32	цоорхой	цэг
16	ханан	шугам	33	эрэг, эрэгцэг	шугам
17	ховол	шугам			

### 1.3. Мэдээллийн сангийн давхарга

Мэдээллийн санд тодорхойлогдсон үндсэн ангилалын багц өгөгдлүүд нь тус бүр цэг, шугам, талбайн давхарга агуулна. Давхаргын нэр болон давхарга бүрт байх талбарын нэр, талбарын төрөл, тэмдэгтийн уртыг Хүснэгт 2-т үзүүлсэн байдлаар тодорхойлно.

Хүснэгт 2 Мэдээллийн сангийн давхаргууд

Давхаргын нэр	Талбарын нэр	Талбар - ын төрөл	Тэмдэгт-ийн урт	Тайлбар
natural_P	PID	text	10	Газар зүйн нэрийн дахин давтагдашгүй дугаар
	GN_nerMon	text	50	Газар зүйн Монгол нэр
	GN_nerEng	text	50	Газар зүйн Англи галигласан нэр
	aimag	text	50	тухайн ГЗН байрлаж буй аймгийн нэр
	sum	text	50	тухайн ГЗН байрлаж буй сумын нэр
	majorClass	text	20	ГЗН-ийн үндсэн ангилал
	mediumClass	short integer	-	ГЗН-ийн дэд ангилал
	minorClass	text	20	ГЗН-ийн анхдагч ангилал
	approveUIH	text	50	УИХ-ын тогтоолоор батлагдсан эсэх
	scale25000	text	50	тухайн ГЗН 1:25 000-ны масштабтай зурагт орсон эсэх
scale100000	text	50	тухайн ГЗН 1:100 000-ны масштабтай зурагт орсон эсэх	
natural_L	PID	text	10	Газар зүйн нэрийн дахин давтагдашгүй дугаар
	GN_nerMon	text	50	Газар зүйн Монгол нэр
	GN_nerEng	text	50	Газар зүйн Англи галигласан нэр
	aimag	text	50	тухайн ГЗН байрлаж буй аймгийн нэр
	sum	text	50	тухайн ГЗН байрлаж буй сумын

				нэр
	majorClass	text	20	ГЗН-ийн үндсэн ангилал
	mediumClass	short integer	-	ГЗН-ийн дэд ангилал
	minorClass	text	20	ГЗН-ийн анхдагч ангилал
	approveUIH	text	50	УИХ-ын тогтоолоор батлагдсан эсэх
	scale25000	text	50	Тухайн ГЗН 1:25 000-ны масштабтай зурагт орсон эсэх
	scale100000	text	50	Тухайн ГЗН 1:100 000-ны масштабтай зурагт орсон эсэх
<b>natural_A</b>	PID	text	10	Газар зүйн нэрийн дахин давтагдашгүй дугаар
	GN_nerMon	text	50	Газар зүйн Монгол нэр
	GN_nerEng	text	50	Газар зүйн Англи галигласан нэр
	aimag	text	50	тухайн ГЗН байрлаж буй аймгийн нэр
	sum	text	50	тухайн ГЗН байрлаж буй сумын нэр
	majorClass	text	20	ГЗН-ийн үндсэн ангилал
	mediumClass	short integer	-	ГЗН-ийн дэд ангилал
	minorClass	text	20	ГЗН-ийн анхдагч ангилал
	approveUIH	text	50	УИХ-ын тогтоолоор батлагдсан эсэх
	scale25000	text	50	тухайн ГЗН 1:25 000-ны масштабтай зурагт орсон эсэх
	scale100000	text	50	тухайн ГЗН 1:100 000-ны масштабтай зурагт орсон эсэх
<b>administration_P</b>	PID	text	10	Газар зүйн нэрийн дахин давтагдашгүй дугаар
	GN_nerMon	text	50	Газар зүйн Монгол нэр
	GN_nerEng	text	50	Газар зүйн Англи галигласан нэр
	aimag	text	50	тухайн ГЗН байрлаж буй аймгийн нэр
	sum	text	50	тухайн ГЗН байрлаж буй сумын нэр
	majorClass	text	20	ГЗН-ийн үндсэн ангилал
	mediumClass	short integer	-	ГЗН-ийн дэд ангилал
	minorClass	text	20	ГЗН-ийн анхдагч ангилал
	approveUIH	text	50	УИХ-ын тогтоолоор батлагдсан эсэх
	scale25000	text	50	тухайн ГЗН 1:25 000-ны масштабтай зурагт орсон эсэх
	scale100000	text	50	тухайн ГЗН 1:100 000-ны масштабтай зурагт орсон эсэх
<b>administration_L</b>	PID	text	10	Газар зүйн нэрийн дахин давтагдашгүй дугаар
	GN_nerMon	text	50	Газар зүйн Монгол нэр
	GN_nerEng	text	50	Газар зүйн Англи галигласан нэр

	aimag	text	50	тухайн ГЗН байрлаж буй аймгийн нэр
	sum	text	50	тухайн ГЗН байрлаж буй сумын нэр
	majorClass	text	20	ГЗН-ийн үндсэн ангилал
	mediumClasses	short integer	-	ГЗН-ийн дэд ангилал
	minorClass	text	20	ГЗН-ийн анхдагч ангилал
	approveUIH	text	50	УИХ-ын тогтоолоор батлагдсан эсэх
	scale25000	text	50	тухайн ГЗН 1:25 000-ны масштабтай зурагт орсон эсэх
	scale100000	text	50	тухайн ГЗН 1:100 000-ны масштабтай зурагт орсон эсэх
<b>administration_A</b>	PID	text	10	Газар зүйн нэрийн дахин давтагдашгүй дугаар
	GN_nerMon	text	50	Газар зүйн Монгол нэр
	GN_nerEng	text	50	Газар зүйн Англи галигласан нэр
	aimag	text	50	тухайн ГЗН байрлаж буй аймгийн нэр
	sum	text	50	тухайн ГЗН байрлаж буй сумын нэр
	majorClass	text	20	ГЗН-ийн үндсэн ангилал
	mediumClasses	short integer	-	ГЗН-ийн дэд ангилал
	minorClass	text	20	ГЗН-ийн анхдагч ангилал
	approveUIH	text	50	УИХ-ын тогтоолоор батлагдсан эсэх
	scale25000	text	50	тухайн ГЗН 1:25 000-ны масштабтай зурагт орсон эсэх
scale100000	text	50	тухайн ГЗН 1:100 000-ны масштабтай зурагт орсон эсэх	
<b>man made_P</b>	PID	text	10	Газар зүйн нэрийн дахин давтагдашгүй дугаар
	GN_nerMon	text	50	Газар зүйн Монгол нэр
	GN_nerEng	text	50	Газар зүйн Англи галигласан нэр
	aimag	text	50	тухайн ГЗН байрлаж буй аймгийн нэр
	sum	text	50	тухайн ГЗН байрлаж буй сумын нэр
	majorClass	text	20	ГЗН-ийн үндсэн ангилал
	mediumClasses	short integer	-	ГЗН-ийн дэд ангилал
	minorClass	text	20	ГЗН-ийн анхдагч ангилал
	approveUIH	text	50	УИХ-ын тогтоолоор батлагдсан эсэх
	scale25000	text	50	тухайн ГЗН 1:25 000-ны масштабтай зурагт орсон эсэх
scale100000	text	50	тухайн ГЗН 1:100 000-ны масштабтай зурагт орсон эсэх	
<b>man made_L</b>	PID	text	10	Газар зүйн нэрийн дахин

				давтагдашгүй дугаар
	GN_nerMon	text	50	Газар зүйн Монгол нэр
	GN_nerEng	text	50	Газар зүйн Англи галигласан нэр
	aimag	text	50	тухайн ГЗН байрлаж буй аймгийн нэр
	sum	text	50	тухайн ГЗН байрлаж буй сумын нэр
	majorClass	text	20	ГЗН-ийн үндсэн ангилал
	mediumClass	short integer	-	ГЗН-ийн дэд ангилал
	minorClass	text	20	ГЗН-ийн анхдагч ангилал
	approveUIH	text	50	УИХ-ын тогтоолоор батлагдсан эсэх
	scale25000	text	50	тухайн ГЗН 1:25 000-ны масштабтай зурагт орсон эсэх
	scale100000	text	50	тухайн ГЗН 1:100 000-ны масштабтай зурагт орсон эсэх
<b>man made_A</b>	PID	text	10	Газар зүйн нэрийн дахин давтагдашгүй дугаар
	GN_nerMon	text	50	Газар зүйн Монгол нэр
	GN_nerEng	text	50	Газар зүйн Англи галигласан нэр
	aimag	text	50	тухайн ГЗН байрлаж буй аймгийн нэр
	sum	text	50	тухайн ГЗН байрлаж буй сумын нэр
	majorClass	text	20	ГЗН-ийн үндсэн ангилал
	mediumClass	short integer	-	ГЗН-ийн дэд ангилал
	minorClass	text	20	ГЗН-ийн анхдагч ангилал
	approveUIH	text	50	УИХ-ын тогтоолоор батлагдсан эсэх
	scale25000	text	50	тухайн ГЗН 1:25 000-ны масштабтай зурагт орсон эсэх
	scale100000	text	50	тухайн ГЗН 1:100 000-ны масштабтай зурагт орсон эсэх

Үндсэн ангилалын домэйн утгыг Н – засаг захиргаа, В – байгаль, F – хүний бүтээсэн гэж, анхдагч ангилалын домэйн утгыг Хүснэгт 1-т байх анхдагч ангилалын төрлөөр тодорхойлно. Дэд ангилалыг мэдээллийн санд дэд төрөл /subtype/ байдлаар үүсгэж өгнө.

Давхарга бүрийн approveUIH, scale25000, scale100000 талбаруудад тийм, үгүй гэсэн домэйн утга тодорхойлж өгнө.

#### 1.4. Газар зүйн нэр бүрийн дугаарлалт

Газар зүйн нэр бүр дахин давтагдашгүй дугаартай байна. Газар зүйн нэрийн дахин давтагдашгүй дугаар нь үндсэн ангилалыг тодорхойлсон үсэг, дэд ангилал, анхдагч ангилалын тус бүрийн дэс дугаар /Хүснэгт 1-т байгаа/, тухайн нэрийг мэдээллийн санд оруулахад автоматаар үүсэх дугаарын бүрдэл байна. /Хүснэгт 3/ Хүснэгт 3 Газар зүйн нэр бүрийн дугаарлалт

PID	Тайлбар	
<b>B01150000</b>	<b>B</b>	Үндсэн ангилалын үсгэн тэмдэглээ /B - байгаль/

1	01	Тухайн үндсэн ангилал доторх дэд ангилалын дугаар /01 - уул/
	15	Тухайн дэд ангилал доторх анхдагч ангилалын дугаар /15 - нуруу/
	00001	Газар зүйн нэрийн мэдээллийн сан дахь дугаар /1 дугаартай объект/
F02080000 1	F	Үндсэн ангилалын үсгэн тэмдэглээ /F - хүний бүтээсэн/
	02	Тухайн үндсэн ангилал доторх дэд ангилалын дугаар /02 – барилга, байгууламж/
	08	Тухайн дэд ангилал доторх анхдагч ангилалын дугаар /08 - гүүр/
	00100	Газар зүйн нэрийн мэдээллийн сан дахь дугаар /100 дугаартай объект/
H01020001 2	H	Үндсэн ангилалын үсгэн тэмдэглээ /H - Засаг захиргаа/
	01	Тухайн үндсэн ангилал доторх дэд ангилалын дугаар /01 - Засаг захиргааны нэгж/
	02	Тухайн дэд ангилал доторх анхдагч ангилалын дугаар /02 - аймаг/
	00012	Газар зүйн нэрийн мэдээллийн сан дахь дугаар /12 дугаартай объект/

#### 1.5. Мэдээллийн сангийн хүснэгтэн мэдээлэл /атрибут/

Газар зүйн нэрийн мэдээллийн сан нь байршил, метадата, архивын мэдээлэл агуулсан 9 хүснэгтэн мэдээлэлтэй. Байршил болон метадата мэдээлэл агуулсан хүснэгтэн мэдээллийг цэг, шугам, талбайн төрлөөр үүсгэнэ. Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгөд нэр өгсөн ИТХТ-ийн тогтоолын талаарх мэдээллийг нэг хүснэгтэнд хөтөлнө. Газар зүйн нэр өөрчилсөн УИХ болон ИТХТ-ийн тогтоолын талаар архивын мэдээллийг тус тусад нь хүснэгтэнд хөтөлнө. Эдгээр хүснэгтийн нэр, талбарын нэр, тэмдэгтийн уртыг Хүснэгт 4-т үзүүлсэн дагуу тодорхойлно.

Хүснэгт 4 Газар зүйн нэрийн мэдээллийн сангийн хүснэгтэн мэдээлэл

Хүснэгтийн нэр	Талбарын нэр	Талбарын төрөл	Тэмдэгт-ийн урт	Тайлбар
LocationP	PID	text	10	Газар зүйн нэрийн дахин давтагдашгүй дугаар
	B_gradWGS84	double	-	WGS84 солбицолд тодорхойлсон өргөрөгийн градус
	B_minWGS84	double	-	WGS84 солбицолд тодорхойлсон өргөрөгийн минут
	B_secWGS84	double	-	WGS84 солбицолд тодорхойлсон өргөрөгийн секунд
	L_gradWGS84	double	-	WGS84 солбицолд тодорхойлсон уртрагийн градус
	L_minWGS84	double	-	WGS84 солбицолд тодорхойлсон уртрагийн минут
	L_secWGS84	double	-	WGS84 солбицолд тодорхойлсон уртрагийн секунд
	H_elevOrtho	double	7	Балтийн
LocationL	PID	text	10	Газар зүйн нэрийн дахин давтагдашгүй дугаар
	B_gradWGS84s	double	-	WGS84 солбицолд тодорхойлсон өргөрөгийн градус /шугамын эхлэл/

	B_minWGS84s	double	-	WGS84 солбицолд тодорхойлсон өргөрөгийн минут /шугамын эхлэл/
	B_secWGS84s	double	-	WGS84 солбицолд тодорхойлсон өргөрөгийн секунд /шугамын эхлэл/
	L_gradWGS84s	double	-	WGS84 солбицолд тодорхойлсон уртрагийн градус /шугамын эхлэл/
	L_minWGS84s	double	-	WGS84 солбицолд тодорхойлсон уртрагийн минут /шугамын эхлэл/
	L_secWGS84s	double	-	WGS84 солбицолд тодорхойлсон уртрагийн секунд /шугамын эхлэл/
	B_gradWGS84e	double	-	WGS84 солбицолд тодорхойлсон өргөрөгийн градус /шугамын төгсгөл/
	B_minWGS84e	double	-	WGS84 солбицолд тодорхойлсон өргөрөгийн минут /шугамын төгсгөл/
	B_secWGS84e	double	-	WGS84 солбицолд тодорхойлсон өргөрөгийн секунд /шугамын төгсгөл/
	L_gradWGS84e	double	-	WGS84 солбицолд тодорхойлсон уртрагийн градус /шугамын төгсгөл/
	L_minWGS84e	double	-	WGS84 солбицолд тодорхойлсон уртрагийн минут /шугамын төгсгөл/
	L_secWGS84e	double	-	WGS84 солбицолд тодорхойлсон уртрагийн секунд /шугамын төгсгөл/
<b>LocationA</b>	PID	text	10	Газар зүйн нэрийн дахин давтагдашгүй дугаар
	B_gradWGS84	double	-	WGS84 солбицолд тодорхойлсон өргөрөгийн градус
	B_minWGS84	double	-	WGS84 солбицолд тодорхойлсон өргөрөгийн минут
	B_secWGS84	double	-	WGS84 солбицолд тодорхойлсон өргөрөгийн секунд
	L_gradWGS84	double	-	WGS84 солбицолд тодорхойлсон уртрагийн градус
	L_minWGS84	double	-	WGS84 солбицолд тодорхойлсон уртрагийн минут
	L_secWGS84	double	-	WGS84 солбицолд тодорхойлсон уртрагийн секунд
<b>MD_P</b>	PID	text	10	Газар зүйн нэрийн дахин давтагдашгүй дугаар
	decreeUIH	text	50	УИХ-ын тогтоолын дугаар
	approveYear	date	-	УИХ-ын тогтоол батлагдсан огноо

	createdUser	text	50	Мэдээлэл оруулсан этгээд
	createdDate	date	-	Мэдээлэл оруулсан огноо
	source	text	150	ГЗН-ийн эх сурвалжийн талаарх мэдээлэл
<b>MD_L</b>	PID	text	10	Газар зүйн нэрийн дахин давтагдашгүй дугаар
	decreeUIH	text	50	УИХ-ын тогтоолын дугаар
	approveYear	date	-	УИХ-ын тогтоол батлагдсан огноо
	createdUser	text	50	Мэдээлэл оруулсан этгээд
	createdDate	date	-	Мэдээлэл оруулсан огноо
	source	text	150	ГЗН-ийн эх сурвалжийн талаарх мэдээлэл
<b>MD_A</b>	PID	text	10	Газар зүйн нэрийн дахин давтагдашгүй дугаар
	decreeUIH	text	50	УИХ-ын тогтоолын дугаар
	approveYear	date	-	УИХ-ын тогтоол батлагдсан огноо
	createdUser	text	50	Мэдээлэл оруулсан этгээд
	createdDate	date	-	Мэдээлэл оруулсан огноо
	source	text	150	ГЗН-ийн эх сурвалжийн талаарх мэдээлэл
<b>ITHT</b>	PID	text	10	Газар зүйн нэрийн дахин давтагдашгүй дугаар
	decreeITHT	text	50	ИТХТ-ийн тогтоолын дугаар
	approveYear	date	-	ИТХТ-ийн тогтоол батлагдсан огноо
	createdUser	text	50	Мэдээлэл оруулсан этгээд
	createdDate	date	-	Мэдээлэл оруулсан огноо
<b>ArchiveUIH</b>	PID	text	10	Газар зүйн нэрийн дахин давтагдашгүй дугаар
	oldGN_nerMon	text	50	Хүчин төгөлдөр бус болсон ГЗН-ийн Монгол нэр
	oldGN_nerEng	text	50	Хүчин төгөлдөр бус болсон ГЗН-ийн Англи галигласан нэр
	oldDecreeUIH	text	50	Хүчин төгөлдөр бус болсон УИХ-ын тогтоолын дугаар
	oldDecreeYear	date	-	Хүчин төгөлдөр бус болсон УИХ-ын тогтоол батлагдсан огноо
	description	text	250	Тайлбар
<b>ArchiveITHT</b>	PID	text	10	Газар зүйн нэрийн дахин давтагдашгүй дугаар
	oldGN_nerMon	text	50	Хүчин төгөлдөр бус болсон ГЗН-ийн Монгол нэр
	oldGN_nerEng	text	50	Хүчин төгөлдөр бус болсон ГЗН-ийн Англи галигласан нэр
	oldDecreeITHT	text	50	Хүчин төгөлдөр бус болсон ИТХТ-ийн тогтоолын дугаар
	oldDecreeYear	date	-	Хүчин төгөлдөр бус болсон ИТХТ-ийн тогтоол батлагдсан огноо

	description	text	250	Тайлбар
--	-------------	------	-----	---------

MD\_P, MD\_L, MD\_A, ITHT хүснэгтэд газар зүйн нэрийг батласан хамгийн сүүлийн хүчин төгөлдөр тогтоолын мэдээллийг оруулна. Архивийн чанартай мэдээлэл оруулах хүснэгтэд хүчингүй болсон тогтоол болон хүчингүй болсон шалтгааны тайлбар мэдээллийг оруулна.

## **ХОЁР. ГАЗАР ЗҮЙН НЭРИЙН МЭДЭЭЛЛИЙН САНД ГАЗАР ЗҮЙН НЭРИЙГ БИЧИХ**

### **2.1. Газар зүйн нэрийг бичих аргачлал**

- Газар зүйн нэр нь оноосон нэр, дэвсгэр нэрээс бүтсэн байна. Оноосон нэр нь давхар давхар тодотгол бүхий 2-7 үгтэй байж болно. Дэвсгэр нэр нь мэдээллийн сангийн анхдагч ангилалаар тодорхойлогдно.
- Оноосон нэр хэдэн үгтэй байхаас үл хамааран ямагт том үсгээр эхлэн бичнэ. Жишээлбэл: Ааргийн ам, Улхтын ам, хоёр үгнээс бүтсэн: Хөх Довын ухаа, Шилийн Богд уул, гурван үгнээс бүтсэн: Урд Адуун Чулуут толгой, Зүүн Бор Хань уул, дөрвөн үгнээс бүтсэн: Цагаан Хөтөлийн Зүүн Түнтгэр уул, Урт Улаан Ухаагийн Сүүл толгой гэх мэт
- Дэвсгэр /анхдагч ангилал/ нэрийг жижиг үсгээр бичнэ. Харин дэвсгэр /анхдагч ангилал/ нэр нь оноосон нэрийн бүрэлдэхүүнд багтсан бол дээрх дүрэм ёсоор томоор бичигдэнэ. Жишээлбэл: Шар Хадны Өндөр хэц, Өвөр Шандын Уст горхи, Урт Улаан Ухаагийн Сүүл толгой, Өндөр Толгой уул, Салхитын Сүүж толгой, Дөрвөлжин Цагаан Толгой уул гэх мэт
- Газар зүйн нэрээр тодотгосон бригад, ферм, тасаг, суурь, үтрэм зэрэг байгууламжуудын дэвсгэр /анхдагч ангилал/ нэрийг жижиг үсгээр, оноосон нэрийг том үсгээр эхлэн бичнэ. Жишээлбэл: Улаан Толгойн бригад, Хөшөөтийн Амны ферм, Баян Голын суурь гэх мэт.



## ГУРАВ. ГАЗАР ЗҮЙН НЭРИЙН МЭДЭЭЛЛИЙН САНД ГАЗАР ЗҮЙН НЭРИЙГ ЛАТИН ҮСГЭЭР ГАЛИГЛАХ

Газар зүйн нэрийн мэдээллийн санд газар зүйн нэрийг Латин үсгээр галиглахдаа Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2012 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаар баталсан Монгол кирилл үсгийн Латин хөрвүүлэг MNS 5217:2012 стандартыг баримтлан хөрвүүлнэ. Зураг 1

Зураг 1

**Монгол хэлний кирил цагаан толгойн үсгийг хөрвүүлэх**

№	Кирил үсэг		Латин үсэг		Хөрвүүлэх жишээ	
	Том	Жижиг	Том	Жижиг	Латин үсгээр	Кирил үсгээр
1	А	а	A	a	Avarga, khalbaga, aav	Аварга, халбага, аав
2	Б	б	B	b	Baga, sambar	Бага, самбар
3	В	в	V	v	Avarga, vagon, sav	Аварга, вагон, сав
4	Г	г	G	g	Gazar, geree, khereg	Газар, гэрээ, хэрэг
5	Д	д	D	d	Dadlaga, akhmad	Дадлага, ахмад
6	Е	е	Ye	ye	Yeeven, yerööl	Еэвэн, ерөөл
7	Ё	ё	Yo	yo	yorool, oyodol	Ёроол, оёдол
8	Ж	ж	J	j	Juulchin, ajil, Jon	Жуулчин, ажил, Жон
9	З	з	Z	z	Zam, azarga, baaz	Зам, азарга, бааз
10	К	к	K	k	Kino, kilometr, akademi	Кино, километр, академи
11	И	и	I	i	Ishig, bichig, khani	Ишиг, бичиг, хань
12	Й	й	I	i	Iim, eejiin	Ийм, ээжийн
13	Л	л	L	l	Lam, alag, mal	Лам, алаг, мал
14	М	м	M	m	Mal, khamar, nam	Мал, хамар, нам
15	Н	н	N	n	Nar, khana, ünen	Нар, хана, үнэн
16	О	о	O	o	Oron, bolovсроl, тооно	Орон, боловсрол, тооно
17	Ө	ө	Ö	ö	Ödör, önöödör, ööröösöö	Өдөр, өнөөдөр, өөрөөсөө
18	П	п	P	p	Puujin, aparat	Пуужин, аппарат
19	Р	р	R	r	rashaan, radio, sar	Рашаан, радио, сар
20	С	с	S	s	Sar, asar, etses	Сар, асар, эцэс
21	Т	т	T	t	Tamga, tatlaga	Тамга, татлага
22	У	у	U	u	Uran, nuruu	Уран, нуруу
23	Ү	ү	Ü	ü	Ünen, түргэн, тэргүүн	Үнэн, түргэн, тэргүүн
24	Ф	ф	F	f	Foto, fond	Фото, фонд
25	Х	х	Kh	kh	khavar, nökhör, ekh	Хавар, нөхөр, эх
26	Ц	ц	Ts	ts	Tsatsag, tsetseg	Цацаг, цэцэг
27	Ч	ч	Ch	ch	Chimeg, chadal, ach	Чимэг, чадал, ач
28	Ш	ш	Sh	sh	Shashin, aash	Шашин, ааш,
29	Щ	щ	Sh	sh	Shedrin, Shors,	Щедрин, щорс
30	Ъ	ъ	I	i	Oriyo, suriya, gariya,	Орьё, сурья, гарья
31	Ы	ы	Y	y	Khaany, akhyn	Хааны, ахын
32	Ь	ь	I	i	Khari, bari	Харь, барь
33	Э	э	E	e	Ezen, ene, emeel	Эзэн, энэ, эмээл
34	Ю	ю	Yu	yu	Yum, yuüden	Юм, юүдэн
35	Я	я	Ya	ya	Yamar, yaduu, aya	Ямар, ядуу, ая

## ДӨРӨВ. ГАЗАР ЗҮЙН НЭРИЙГ БАЙР ЗҮЙН ЗУРАГТ БИЧИХ

4.1. Газар зүйн нэрийн мэдээллийн санд тусгагдсан нийт газар зүйн нэрийг байр зүйн зураг бичихдээ шаардлагатай нэрийг мэдээллийн сангаас ерөнхийлчлөх байдлаар гаргаж авч “Байр зүйн зургийн загвар сан, таних тэмдэг, Масштаб:1:25 000, 1:50 000, 1:100 000 MNS 6703 : 2017”, “Байр зүйн болон дэвсгэр зургийн загвар сан, таних тэмдэг, Масштаб:1:500, 1:1 000, 1:2 000, 1:5 000, MNS 6702 : 2017” стандартыг баримтлан бичнэ.

4.2. Газар зүйн нэрийн мэдээллийн сангаас нэрүүдийг байр зүйн зургийг мэдээллийн санд хөрвүүлэн оруулж болох бөгөөд “Байр зүйн зургийн загвар сан, таних тэмдэг, Масштаб:1:25 000, 1:50 000, 1:100 000 MNS 6703 : 2017”, “Байр зүйн болон дэвсгэр зургийн загвар сан, таних тэмдэг, Масштаб:1:500, 1:1 000, 1:2 000, 1:5 000, MNS 6702 : 2017” стандартын мэдээллийн сангийн давхаргын дагуу хөрвүүлэн ашиглана.

4.3. Дэвсгэр /анхдагч ангилал/ нэрийг байр зүйн зурагт товчлон бичиж болох бөгөөд нэрийн товчлолыг “Байр зүйн зургийн загвар сан, таних тэмдэг, Масштаб:1:25 000, 1:50 000, 1:100 000 MNS 6703 : 2017”, “Байр зүйн болон дэвсгэр зургийн загвар сан, таних тэмдэг, Масштаб:1:500, 1:1 000, 1:2 000, 1:5 000, MNS 6702 : 2017” стандартын дагуу бичнэ.

### ТАВ. ДЭВСГЭР БУЮУ АНХДАГЧ АНГИЛЛЫН ТАЙЛБАР

Газар зүйн нэрийн мэдээллийн сангийн анхдагч ангилалын тайлбайр хүснэгт5

Хүснэгт5

01	Уул	
01	аараг	Жалга судаг, барзан сархиаг ихтэй газар: Аараг ихтэй (жалга судаг ихтэй), хар аараг (барзан сархиаг ихтэй газрын нэр) аараг толгод (жижиг хадтай толгод).
02	адарга	Газрын гадаргын атираа, нугачаа, үелсэн намхан толгод
03	ам	Уул, нурууны салбарласан өндөр хянга, хамруудын хооронд орших хавчиг хөндий
04	асга	Уул, хавцал зэрэг газарт хэсэг хэсгээр овооролдон орших сул хад чулуу
05	байц	Эгц халил, бэрх газар
06	богоч	Уулын бяцхан онь хөтөл
07	бөөрөг	Уулын хажуу этгээдийн дэвсгэр ихтэй газар
08	бэл	Уулын хажуугийн шувтрах налуу газар
02	адарга	Газрын гадаргын атираа, нугачаа, үелсэн намхан толгод
09	даваа, дав, онь	Замд хөндөлсөх өндөр агаад давахад хэцүү, бартаа бүхий нуруу газар
10	дөрөлж	Уул, ухаа, хамар газрын гудас хөтөл
11	ёроол	Уулын хажуу бэл: <b>Уулын ёроол</b>
12	зоо	Уудам, гүдгэр газар: <b>Уулын зоо</b> (уулын оройн гүдгэр хэсэг), <b>зоо дэл</b>
13	зураа	Уул нуруунаас доош салбарласан нарийн урт гүдгэр газар: <b>Уулын зураа</b>
14	зээг	Цуварсан байдалтай: <b>Зээг толгод</b> (цувраа толгод)
15	нуруу	Уулын урт зоо болон үргэлжилсэн уулс
16	овоо	Уул, даваан дээр мод, чулуу овоолж босгосон газар
17	орой, оргил,	Уулын ноён орой, дээд тал, уул толгой, даваа гүвээний хамгийн өндөр хэсэг

	өндөрлөг, өндөр	
18	өвөр	Уулын энгэр, нөмөр хэсэг
19	салаа	Нэг эхээс салбарласан ацтай зүйл, нэг эхтэй олон салбар урсгалтай гол
20	сархиа, сархиаг, сархид	Олон гүнзгий гуу жалга, хад асга, нугачаатай, энхэл донхол, хотгор гүдгэр газар
21	сарьдаг	Мөнх цаст уул
22	суга	Уулын хажуугийн завсар
23	сэрвэн	Уулын сэрвэгэр сэртгэр хэсэг
24	таг	Уулын тэгш орой: <b>Тагийн бүс</b> (өндөр уулын бүс)
25	тайга	Хөндөгдөөгүй ой хөвч бүрхсэн өтгөн шигүү, өндөр аглаг уул нуруу
26	толгод	Олон жижиг толгой
27	толгой, болдог	Тал газар тасархайтан тогтсон товгор газар
28	уул, хайрхан	Эргэн тойрны орчноос онцгойрон ялгарч, оргил, нуруу хэлбэрээр хоёр зуун метрээс дээш өргөгдсөн газрын гадарга
29	ухаа	Талархуу газар буй өндөрхөн зоо газар
30	хавцал	Гүн нь ихэвчлэн өргөнөөсөө их уулын эгц хажуутай нарийн хөндий
31	хамар, өвдөг, гэзэг	Үргэлжилсэн уулын хяр, хөтөл: <b>Хамар давах</b>
32	хормой	Уулын бэлийн доод этгээдийн газар: <b>Уулын хормой</b>
33	хунх, хүнх	<b>Хонхор газар (нам дор газар)</b>
34	хүнхэр	<b>Хонхор газар (нам дор газар)</b>
35	хүр, хүрд	<b>Хонхор газар (нам дор газар)</b>
36	хэц	Уул нуруу, хад асгын цавчим өндөр, огцом налуу газар
37	хяр, хянга	Өндөрлөг уулс, нуруудын дээд ирмэг, хянга
38	хясаа	Уулын халилын ирмэг, усны захын эргэцэг мэт явах зорчиход бэрх хэцүү эгц өндөр хадан хавцал
39	цав	Уулын хоёр талын жигүүрийн өндөр газар
40	царам	Уулын хяр, хөндий, хоолой, хөвч мэтийн өндөр газарт жавар, сэрүүн хялбар тусах газар
41	шил	Уулын өндөрлөг хянга, уул толгодын арын нам газар,
42	энгэр, ташуу, цалуу, нураг, нурган, нахиу	Уулын наран тал, уулын нөмөр хэсэг, налуу хэсэг
<b>02</b>	<b>Амьтан, ургамал</b>	
01	айраг	Нэгэн төрлийн ургамал
02	бургас, бут, бударгана, бураа, арц, сондуул, торлог, хармаг, сухай	Бутлан ургадаг сөөглөг ургамал

03	дэрс	Үет ургамлын язгуур; сайр нуга, хээр тал, хужирлаг цайдамд ургадаг, хавтгай урт навчтай, хатуу нарийн иштэй, буталж ургадаг олон наст өвс
04	заг	Говь газар ургадаг, цагаан дурстай, хайрслаг чагтан навчтай, найлзуур нь шилмүүсний хэлбэртэй, буурцгийн дотоодод цагариг ногоон үртэй, яслас хатуу нэг зүйл мод
05	мод	Бүдүүн хатуу иштэй олон наст ургамал
06	нарс	Бөөрөнхий боргоцойтой, мөнх ногоон, урт хос шилмүүстэй нэгэн зүйл мод
07	нуга, ширэг, зүлэг, таана	Голын хөвөө дагуу болон уул нуруу, даваа гүвээ зэрэг газрын хөндий дэх чийг ихтэй өвс, ногоо сайн ургадаг булан тохой
08	ой, төгөл, хөвч	Мод бүрхэн ургасан газар
09	сөөг, шаваг, шарилж	Модорхог өндөр, олон иштэй бут сөөг
10	түнгэ, ширэнгэ, шугуй	Чигжүү ургасан мод сөөг, ой дотор нягт шигүү ургасан мод
11	тэсэг	Луультан овгийн гучаас тавин сантиметр орчим өндөр, ёзоороосоо олон салаалсан иштэй, үслэг цайвар навчтай, өвөл хаврын цагт малд тэжээлтэй, говь хээрийн бүсэд бутаар ургадаг заримдаг сөөгөнцөр
12	улиас	Бургастан овгийн навчит мод
13	хаг	Хад, чулуу, хөрсний гадарга дээр гол төлөв ургадаг өнгөр
14	хайлаас, хайлс	Уян бөгөөд бөх чанартай навчит мод
15	харгайт	Гацууртай адил болоод яс чийрэг, чанар хүнд, дурс зузаан, уул хөвчийн чийглэг жихүүн газарт ургадаг нэгэн зүйл мод
16	харгана	Буурцагтан овгийн төрөл, модлог сөөг наяд орчим зүйлтэй
17	хулс	Усны хөвөөгөөр ургадаг, сүрэл нь хөндий, гялгар, хавтга шөвөг хэлбэрт навчтай, цэцэг нь бор, доод талдаа олон ширхэг шиг үстэй, сүрлээр нь чийрс гөрөх буюу цаас хийдэг олон наст өвс
18	хус, боролж	Цагаан өнгөтэй, бяцхан навчтай, нарийн болоод чийрэг нэг зүйл мод
<b>03</b>	<b>Хөрс, чулуулаг</b>	
01	марз, мараа	Мал гөрөөсний идэх мараа хужир, шорвог эрдэстэй газар
02	намаг	Зүлэг шавартай нойтон, чийгтэй бамбалзуур газар, ургамлын өвөрмөц бүрхэвчтэй, ихэнхдээ хүлэр агуулсан, хэт чийгшилтэй хуурай газрын хэсэг
03	сондог	Бут ургасан наанги хөрстэй дов
04	хайрга, дайрга	Голын усаар угаагдаж мөлийсөн нэн үйрмэг чулуу
05	хаш, хүлэр, зэс, гяваат	Ашигт малтмал
06	чулуу	Байгалийн үлэмж их нягтарсан, олон улсын хөрс судлалын нийгэмлэгийн ангиллаар 2 миллиметрээс дээш голчтой хатуу эрдэс чулуулаг

07	шал, шавар, шалбааг, лах	Намаг, шавхай: Шавар намаг [хоршоо] (өвс ногоо, хөвд зэрэг зүйлтэй ороолдсон нойтон шороо)
08	элс, манхан	Янз бүрийн гарал үүсэл, найрлагатай хурдас чулуулгийн эвдрэл, өгөршлөөс үүссэн жижиг мөхлөгтэй чулуу, олон улсын хөрс судлалын нийгэмлэгийн ангиллаар хоёр миллиметр хүртэлх голчтой жижиг хэсэг
09	явар, цахир, цайдам, борзон	Бүдүүн мөхлөгт, барьцалдсан бат бэх цахиурлаг, хайрганцар чулуу
<b>04</b>	<b>Ус зүй</b>	
01	арал	Нуур далай, гол мөрөн доторх бүх талаараа усаар хүрээлэгдсэн хуурай газар, ойрад нэг зүйлийн зэрлэг жимс, хүн, амьтны нуруу, өндөр
02	боом	Голын усны их урсгал хэсэг
03	булаг	Газар дороос ундрэн гарах ус
04	гарам, олом	Мөрөн голын усыг уналга хөсөг юм уу хөлөг онгоц тэргүүтнээр гатлах тавилан газар
05	гатлага	Гаталж болох газар, гарам, тавилан
06	гол, харз	Газрын доорх болон хөрсний уснаас эх авч өөрийн голдрил саваар байнга урсах байгалийн урсгал ус
07	горхи	Байгалийн бага хэмжээний урсгал ус
08	мөрөн	Голоос том, далай тэнгист цутгадаг урсгал их ус
09	нуур	Хуурай газраар хүрээлэгдсэн их хэмжээний тогтмол ус
10	рашаан	Өвчин эмгэгийг анагаах чадвартай байгалийн эрдэст ус
11	сайр, садарга	Гол, мөрний ус салбарлан урсах голдрил: <b>Мөрний садарга, жалга сархиаг ихтэй газар: Сайр садарга</b>
12	салаа	Нэг эхтэй олон салбар урсгалтай гол
13	суваг, судаг, татаал	Усны урсгалд элэгдэн гарсан нарийн гуу
14	тавилан	Хуурай газрын тээврийн хэрэгсэл, ачаа, зорчигчдыг тээвэрлэн ус гаталгах хөвөгч байгууламж, <b>мөрөн голын гарц, гарам, олом</b>
15	татуурга	Эх голоосоо салж урссан нарийн салаа
16	тойром, цөөрөм	Хур элбэгтэй цагт нуур болж, ус бороо ховор цагт шавар шалбааг болох буюу бүр хатаж хуурайшдаг хужирлаг шороо бүхий халцгай, хонхор газар
17	тохой	Усны тохойрч махирлан урсах газар
18	ус	Булаг шанд, худаг, гол горхи, нуур цөөрөм, далай тэнгис
19	усан сан	А. Усыг нөөцөлж нийтэд түгээх газар; б. Ус хуримтлуулан хашсан цөөрөм
20	хөвөө	Далай, тэнгис, нуур, гол, мөрний зах, хязгаар: Далайн хөвөө (далайн зах, далайн эрэг), мөрний хөвөө
21	худаг	Газрыг гүнзгий ухаж гаргасан устай нүх
22	цутгалан, хүрхэрээ, таргил	Гол мөрнүүдийн, нуур, далай тэнгист хажуугаас нь цутган орж, нийлж байгаа газар, хэц өндөр, хавцал газраас доош цочмог ширүүн цутган буух ус
23	цүнхэг,	Гол мөрний эргэлдсэн гүн устай хэсэг

	цүлхэн, хөв	
24	шанд	Говь газрын бяцхан булаг
<b>05</b>	<b>Зүг чиг байршил</b>	
01	адаг	Газар нутгийн зах, үзүүр хэсэг, нам дор газар: <b>Адаг газар</b> (алс зах нутаг)
02	ар	Умар тийш харсан тал: <b>Уулын ар</b> (уулын хойд этгээд)
03	булан	Ямар нэг юм руу тохойрон түрж орсон газар
04	бэлчир	Зам, голын салбар нийлсэн уулзар газар
05	ганга	Уул толгодын завсар, гуу жалга, цас борооны усанд идэгдэн гарсан суваг
06	говь	Ургамал тачир сийрэг, ой мод ба урсгал ус маш ховор, элс хайрган хөрстэй, тарвага нутагшдаггүй, хээр тал газар
07	гүвээ, гүдгэр, гүдэн, гүрдгэр	Хотгор гэдгийн эсрэг утга, төвгөр, товгор
08	дов, довон, довцог	Овгор товгор газар
09	дэл	Уул нурууны хяраар нарийн зурваслан ургасан хад
10	зааг	Улс орон, газар орон, нутгийн хил нийлсэн газар
11	завсар	Юмны хоорондох зай, ан цав: Уулын завсар буух
12	зах	Газар нутаг, орон байр, талбай зэрэг зүйлийн хөвөө, ирмэг хязгаар
13	нүүр	Нүүгээд буух газар
14	урт	Урт сунасан газар
15	уулзвар	Сайр, зам, хөндий, ам, голын нийлсэн газар
16	үзүүр	Газрын эхлэл төгсгөл, шувтрах буюу дээд хэсэг
17	хаяа	Янз бүрийн тогтоцтой газрын зах, хөвөө, хязгаар
18	эх, эхэн	Аливаа газар зүйн элементийн анх үүсгэл, эхлэл: Голын эх
01	адаг	Газар нутгийн зах, үзүүр хэсэг, нам дор газар: <b>Адаг газар</b> (алс зах нутаг)
02	ар	Умар тийш харсан тал: <b>Уулын ар</b> (уулын хойд этгээд)
03	булан	Ямар нэг газар зүйн объектруу тохойрон түрж орсон газар
04	бэлчир	Зам, голын салбар нийлсэн уулзар газар
05	ганга	Уул толгодын завсар, гуу жалга, цас борооны усанд идэгдэн гарсан суваг
06	говь	Ургамал тачир сийрэг, ой мод ба урсгал ус маш ховор, элс хайрган хөрстэй, тарвага нутагшдаггүй, хээр тал газар
07	гүвээ, гүдгэр, гүдэн, гүрдгэр	Төвгөр, товгор газар
08	дов, довон, довцог	Овгор товгор газар
09	дэл	Уул нурууны хяраар нарийн зурваслан ургасан хад
10	зааг	Улс орон, газар орон, нутгийн хил нийлсэн газар
<b>06</b>	<b>Тогтоц</b>	
01	агуй, хонгил	Газар дор буюу уул хаданд тогтсон, гадагшаа гарах амтай том хөндий нүх, хонгил
02	ан, ангал, гануу	Хад, газар зэрэг хагаран ангайж гүнзгий ан цав гарсан нь

03	барзан	Уул хадны арзгар сэргэн ихтэй байдал
04	бүрд	Говь нутгийн дунд орших ус ургамал тэгш бүрдсэн хэсэгхэн газар
05	гацаа, сүв, мухар	Алс буйд, хол: Газрын мухар, юмны битүү булан: Мухар гудамж (нэвт гарах боломжгүй битүү гудамж)
06	гозгор, шовх, шовгор	Өндөр болоод босоо, шовх хэлбэртэй газар
07	дэнж, дэвсэг, дэв, хавтгай, ширээ	Нам доор газраас арай өндөр мөргөцөгтэй тэгш дүү дэв газар
08	жалга, гуу, зуух	Цас, борооны ус урсаж тогтсон хонхор газар, том, жижиг гуу
09	мөргөцөг, мөргүү, мөрөг, ирмэг, хөмөг	Эрэг жалга бүхий газрын ирмэг зах, аливаа усан сан, голын зүгээс байрлалтай, дэнжийг хязгаарласан хажуу болон тохойрсон газрын эргэцэг
10	овгор, товгор, товог, дүмбэн, оорцог	Овгор, төмбөгөр: Товгор газар
11	огтрого	Газрын хэлбэр
12	тал	Уул даваа, хотгор гүдгэр зэрэг өндрийн хэлбэлзэл бага, уудам тэгш газар
13	тэнгэр	Газрын дээд хэсэгт байх бидний нүднээ үзэгдэх агаар мандал
14	тээг	Суваг жалганы ам болон гарц газрын аманд хөндөлдсөн далан гүвээ, довцог толгой
15	хад, цохио, цонж	Онцгойдуу тогтсон өндөр хад
16	ханан	Газрын хэлбэр
17	ховол	Газрын хэлбэр
18	хонд	Газрын хэлбэр
19	хонхор, хонх, хунхуй, төхөм	Газрын хэлбэр
20	хоолой	Хоёр уулын хоорондох өргөн тавиу газар, хоёр нуурыг холбосон горхи суваг
21	хорголж	Газрын хэлбэр
22	хотгор, хотос	Газрын хэлбэр
23	хошуу	Газрын хэлбэр
24	хөдөө	Суурьшсан хот сууринаас хол нутаг, тариалангүй газар
25	хөндий	Хоёр хэсэг уул нуруу мэтийн хоорондуур үргэлжлэн алсалсан тэгш тавиу газар
26	хөтөл	Уул нурууны дөлгөөн буусан нам газар
27	хургад	Газрын хэлбэр

28	хуруу, шанаа, дух, магнай, сээр, хажуу, сүвээ, хавирга, хөл, сүүл, гуя, тархи	Газрын хэлбэр
29	хуудас	Газрын хэлбэр
30	хүрэм	1. Уулын орой, чээжин биеэр сул чулуу бүрхсэн газар, галт уулын дэлбэрэлтээс бүрэлдэж буй болсон хөнгөн чулуу
31	хүрээ	Байран суурин төв газар: Богдын хүрээ
32	цоорхой	Сул чөлөөтэй, завсар газар
33	эрэг, эрэгцэг	Гол мөрөн, уул хадны хөвөөнд өнгийж тогтсон ирмэг
34	зэрэглээ	Газрын уур дээш хөөрч хөх униар дэгдсэнээс алсын зүйл усны дүр адил харагдах үзэгдэл
35	уур	Цаг агаарын нөхцөл, байдал
36	хур	Агаар мандалд үүл болон хөөрсөн усны уур хүйтэн агаарын нөлөөгөөр шингэн, хатуу хэлбэрт шилжин хуримтлагдаж доош буух